



ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ



E-NEWSLETTER

f facebook.com/Rtcc.m0n
globe http://rtcc.mrtd.gov.mn
envelope info@rtcc.mrtd.gov.mn
phone +976 77244409

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН
2020 оны 09 дугаар сарын дугаар



“ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ” УТҮГ -ЫН БАРИЛГА БАРИХ, ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧАДАВХЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЗАМААР МОНГОЛ УЛСЫН ТӨМӨР ЗАМЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫГ БЭХЖҮҮЛЭХ” ТӨСӨЛ

2019 оны 4-р сард “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ нь БНСУ-ын “КОЙКА” Олон улсын хамтын ажиллагааны байгууллагад “Галт тэрэгний хөдөлгөөний бодит цагийн хяналтын систем болон аюулгүй байдлын хяналтын систем”-ийн төслийн саналыг хүргүүлсэн. Хүсэлтийн дагуу 2019.9.10-16 өдрүүдэд “КОЙКА” ОУХАБ-ын судалгааны 8 хүний бүрэлдэхүүнтэй баг төмөр замын өнөөгийн нөхцөл байдал болон анхан шатны суурь судалгаа хийх зорилгоор Монгол Улсад хүрэлцэн ирсэн. Зам, тээврийн хөгжлийн яам, “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ, “Улаанбаатар төмөр зам” ХНН, “Монголын төмөр зам” ТӨХК-тай тус тус уулзалт зохион байгуулав.



“КОЙКА” ОУХАБ-ын судалгааны баг “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ-тай уулзалт зохион байгуулж төвийн үндсэн чиг үүрэг, алсын харааны хүрээнд тулгуурлан төмөр замын хөдөлгөөний аюулгүй байдлыг бий болгох төрийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, зохицуулалт хийх, улмаар төвийн үйл ажиллагааны чадварыг нэмэгдүүлэх, галт тэрэгний хөдөлгөөний бодит цагийн хяналт, аюулгүй байдлын хяналтын системийг нэвтрүүлсэн мэдээллийн нэгдсэн төв, төвийн барилгыг барих талаар санал хүргүүлэв. “КОЙКА” ОУХАБ-ын Монгол дахь төлөөлөгчийн газар төслийн саналыг дэмжиж төслийн нарийвчилсан судалгааг хийх шаардлагатайг илэрхийлсэн. 2020 онд “КОЙКА” ОУХАБ-аас төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг шийдвэрлэх боломжтой ЗТХЯ-д мэдэгдээд байна.



“ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ” УТУГ -ЫН БАРИЛГА БАРИХ, ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧАДАВХЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЗАМААР МОНГОЛ УЛСЫН ТӨМӨР ЗАМЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫГ БЭХЖҮҮЛЭХ” ТӨСӨЛ

COVID-19 Цар тахлын улмаас нарийвчилсан судалгааг хийх БНСУ-ын судалгааны ажлын баг Монгол Улсад ирэх боломжгүй болж, Монгол улс дахь “КОЙКА” ОУХАБ-ын баг төслийн нарийвчилсан судалгааг хийж байна.

Энэхүү судалгаан ажлын гол зорилго нь:

- ☒ Төмөр замын хяналтын нэгдсэн системийг хөгжүүлэх, “ГТХЗНТ” УТУГ-ын чадавхыг сайжруулах талаар мастер төлөвлөгөө боловсруулах судалгаа;
- ☒ Тасралтгүй тогтвортой систем байгуулах, системийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг бий болгох судалгаа;
- ☒ Төслийг хүрээнд системийн туршилтын төсөл хэрэгжүүлэх, үйл ажиллагаанд нэвтрүүлэх судалгаа;
- ☒ Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн барилгыг барьж байгуулах шаардлагыг тодорхойлох судалгаа;



Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн төсөл хэрэгжих газартай “КОЙКА” ОУХАБ-ын судалгааны баг танилцав. Монгол Улсын төмөр замын салбарт галт тэрэгний хөдөлгөөний бодит цагийн хяналтын нэгдсэн систем, аюулгүй байдлын хяналтын систем камер ашиглан галт тэргийг вагоны дугаараар нь бүртгэх, байршлыг бодит цагаар тодорхойлох, хөдөлгөөний аюулгүй байдлыг зураг болон бичлэгээр хянах, RFID (радио давтамжит долгион)-ийн технологи ашиглан дотоодын вагон бүртгэлийн суурь системийг бий болгох, хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөнийг тодорхойлох, хөдлөх бүрэлдэхүүний засвар үйлчилгээ ашиглалтыг сайжруулах, төмөр замын хөдөлгөөний ажлын үндсэн үзүүлэлтүүдийг бодит цагаар нэгтгэж боловсруулах улмаар төрийн хяналтын тогтолцоог сайжруулах, үр ашигтай нэгдсэн платформ бий болгохыг зорьж байна. Мөн болзошгүй эрсдэл аюулыг тодорхойлох, мэдрэгч сенсорууд тусламжтайгаар байгалийн гамшиг, болзошгүй эрсдэлийг урдчилан мэдэх, шуурхай арга хэмжээ авах замаар дохио илгээх зорилго бүхий системүүдийг туршин нэвтрүүлэхээр ажиллаж байна.



Төрийн зарим ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр хариуцан гүйцэтгэж байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/81 дүгээр тушаал, Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, “ГТХЗНТ” УТҮГ хооронд 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан төрийн зарим ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх тухай 176 дугаартай гэрээний үндсэн дээр Хөдөлгөөн зохицуулалтын төв нь төмөр замын тээврийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл, төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ хүссэн хуулийн этгээдийн хүсэлт, өргөдлийг 05 дугаар сарын 28-ны өдрөөс хүлээн авч ажиллаж байна.

Хөдөлгөөн зохицуулалтын төв нь хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлт, өргөдөл, баримт бичгийг Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу бүртгэж Төмөр замын тээврийн тухай хууль, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмийн хүрээнд баримт бичгийн бүрдэлийг нягтлан энэхүү хариуцлагатай ажил, үйлчилгээг гүйцэтгэж байна.

Төмөр замын тээврийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл

№	Үйл ажиллагааны төрөл	Тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлтийн тоо хэмжээ
Тусгай зөвшөөрөл	Төмөр замын суурь бүтэц угсрах, доод бүтэц барих /далан, хоолой/	16
	Төмөр замын суурь үйлдвэрлэх /замын дээд бүтэц үйлдвэрлэх, замын чигжээс/	9
	Төмөр замын суурь бүтэц угсрах, доод бүтэц барих /далан, хоолой, төмөр бетон болон ган хийцийн гүүр барих/	7
	Суурь бүтэц үйлдвэрлэх замын дээд бүтэц үйлдвэрлэх төмөр бетон дэр үйлдвэрлэх	1
	Ган хийцтэй гүүр барих, хиймэл төхөөрөмж засварлах, төмөр бетон болон ган төмөр гүүр засварлах/	1
	Хөдлөх бүрэлдэхүүн үйлдвэрлэх, угсрах, засварлах	1
	Нийт	35

Төмөр замын тээврийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг шийдвэрлэсэн байдал

№	Ажлын хэсгийн хурлаар шийдвэрлэсэн байдал	Тоо хэмжээ
1	Сайдын тушаалаар шийдвэрлэгдсэн	15
2	Шийдвэрлэгдэх шатанд	10
3	Баримт бичгээ буцаан авсан	1
4	Буцаагдсан	9
5	Нийт	35

Үргэжлэл



Төрийн зарим ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр хариуцан гүйцэтгэж байна.

Тусгай зөвшөөрөл, аюулгүй байдлын гэрчилгээгээр олгогдсон үйл ажиллагаа, объектын төрөл

№	Гэрчилгээгээр олгогдсон үйл ажиллагаа, объектын төрөл	Гэрчилгээ хүссэн хүсэлтийн тоо хэмжээ	
		Сунгасан	Шинээр
Төмөр замын аюулгүй байдалтай холбоотой объектын гэрчилгээ	Хөдлөх бүрэлдэхүүний гэрчилгээ	3	4
	Дагнасан хэрэглээний зам, талбай гэрчилгээ	28	4
Төмөр замын аюулгүй байдалтай холбоотой үйл ажиллагааны гэрчилгээ	Төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагааны гэрчилгээ	14	1
	Төмөр замын зураг төсөл боловсруулах гэрчилгээ	-	2
	Вагоны техникийн үзлэг, үйлчилгээ гүйцэтгэх гэрчилгээ		1
	Нийт	45	12

Төмөр замын тээврийн аюулгүй байдлын гэрчилгээ шийдвэрлэлт

№	Ажлын хэсгийн хурлаар шийдвэрлэн байдал	Тоо хэмжээ
1	Сайдын тушаалаар шийдвэрлэгдсэн	20
2	Шийдвэрлэгдэх шатанд	16
3	Буцаагдсан	21
4	Нийт	57

Төмөр замын тээврийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл, төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ хүсэх үед бүрдүүлэх материал дутуу, хугацаа хоцорсон зэрэг зөрчлүүд их гарч байна.

Иймд тусгай зөвшөөрөл болон гэрчилгээжүүлэх өргөдөл, хүсэлтээ ЗТХЯ, ГТХЗНТ-ийн цахим хуудсанд байршуулсан бүрдүүлэх баримт бичгийн жагсаалттай сайтар танилцаж, бүрэн бүрдүүлж ирүүлж байхыг хүсье.



“ИНЖЕНЕР-ИРЭЭДҮЙ” хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлаас

“Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 4.2.33, 6.8-д тус тус заасныг үндэслэн “Инженер-ирээдүй” хөтөлбөрийг 2019-2029 онд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Тус хөтөлбөрийн зорилго нь салбарын инженер, техникийн ажилчид, эрдэмтэн, судлаач нарын судалгаа, шинжилгээний ажил, ном, бүтээл туурвилыг дэмжих, бүтээлийн тоог нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах, хөгжүүлэх, сурталчлан таниулах, салбарын мэргэжилтэн, инженерүүдийг чадавхжуулах зорилгоор хөрш зэргэлдээ орнуудад тэтгэлэгт хөтөлбөрт хамруулан сургах ажлыг зохион байгуулж туршлага судлах, сургалт, семинарт хамруулах ажлыг үе шаттай зохион байгуулахад оршиж байгаа юм.

Түүнчлэн Салбарын мэргэжилтэн, инженерүүдийн мэдлэг, ур чадвар, суралцах арга барил чиг хандлагыг нэмэгдүүлж хос мэргэжилтэй болгох зорилгоор ОХУ-ын Эрхүүгийн зам харилцааны улсын их сургуультай хамтран “Мэдээллийн систем ба технологи” мэргэжлээр магистрын эчнээ сургалтад хамрагдаж буй мэргэжилтэн, инженерүүдийг 2020 оны 8-р сарын 11-нээс 9-р сарын 04-ний хооронд мэдээлэл технологи, орос хэлний 30 цагийн бэлтгэл сургалтад хамруулж сертификат олгож элсэлтийн шалгалтын үйл ажиллагааг амжилттай зохион байгууллаа.



Мэдээ, мэдээлэл



"Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээний нэгдсэн санг бүрдүүлэн ажиллаж байна.



Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмыг хэрэгжүүлж төмөр замын салбарын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хөтлөх, боловсруулах, ашиглах үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна.

Үндэсний статистикийн хорооны даргын тушаалаар батлагдсан улсын тайлан Т-9 маягтын дагуу 2020 оны 08 дүгээр сарын төмөр замын тээврийн тээвэрлэлтийн мэдээг Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогыг хэрэгжүүлэх газар, Бодлого төлөвлөлтийн газарт хүргэж танилцуулсан.

2020 оны 08 дүгээр сарын статистик мэдээ, мэдээллийг нэгтгэж нийгэм, эдийн засгийн байдалд нөлөөлсөн байдлаар буюу төмөр замын ачаа, зорчигч тээвэрлэлт, ачаа ачилт, зорчигч, ачаа эргэлт, дамжин өнгөрсөн болон тээвэрлэсэн ачаа, галт тэрэгний зурмагийн биелэлтэд дүн шинжилгээ хийж, ЗТХЯ-ны www.mrtcc.gov.mn цахим хуудаст инфографик хэлбэрээр байршуулж олон нийтэд нээлттэй, ил тод мэдээллээ.




"Аюултай хог хаягдлын хүн ам, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл" сэдэвт сургалтад хамрагдлаа.

Зам, тээврийн сайдын 2016 оны 174 дугаар тушаалаар батлагдсан "Зам, тээврийн салбарын хог хаягдлын менежментийн төлөвлөгөө"-нд тусгагдсан арга хэмжээний хүрээнд "Аюултай хог хаягдлын хүн ам, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл" сэдвийн дор БОАЖЯ-ны харьяа "Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв" УТҮГ-аас Судалгаа, мэдээлэл, сургалтын албаны сургалтын арга зүйч Н.Зоригт, Судалгаа, сургалт хариуцсан мэргэжилтэн Н.Амарбаясгалан, Б.Дуламсүрэн нар 2020.09.14-ний өдөр Улаанбаатар хотын өнөөгийн "Агаарын бохирдол" болон "Аюултай хог хаягдал" гэсэн сургалт мэдээллийн арга хэмжээг нийт ажилтнуудад танилцуулж, зохион байгуулсан.




Төмөр замын тээврийн үндсэн үзүүлэлт



2020 оны наймдугаар сард 281.5 мян.зорчигч 2603.7 мян.тн ачаа тээвэрлэсэн байна.


Дамжин өнгөрсөн ачаа /мян.тн/



2020 оны наймдугаар сард 420.5 мян.тн ачаа дамжин өнгөрсөн байна.

Ачилтаар 2020 оны наймдугаар сард нүүрс, төмрийн хүдэр, зэс, молибдений баяжмал өссөн үзүүлэлттэй байна. Нийт 1912 мян.тн ачсан

Ачилт- ачааны төрлөөр /2020 оны 8 дугаар сард/







- Нүүрс 28%
- Төмрийн хүдэр 35%
- Бусад ачаа 11%
- Барилгын материал 17%
- Жонш 3%
- Зэс, молибдений баяжмал 3%
- Нефтийн бүтээгдэхүүн 3%

2020 оны 8 дугаар сард өссөн дүнгээр 1416.7 мян.зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс -25.6-аар буурсан, 19473.5 мян.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 8%-аар өссөн үзүүлэлттэй байна.




ИНФОГРАФИК





Суурь бүтцийн 2020 оны 8-р сарын хөдөлгөөний зурмагийн тасалдлын судалгаа тайлан

2020 оны 8-р сард нийтдээ 129 удаагийн зурмаг тасалдал бүртгэгдсэнээс:



Суурь бүтцийн 2020 оны 8-р сарын нийт тасалдлыг 2019 оны мөн үетэй харьцуулан үзэхэд 38 нэгж буюу 22.75% -иар буурсан үзүүлэлттэй байна.



Зорчигчийн галт тэрэгний явуулалтыг өмнөх оны мөн үетэй харьцуулан үзэхэд 5 нэгж буюу 55.55%-иар буурсан үзүүлэлттэй байна.



**Зорчигчийн галт тэрэгний явуулалт
8 дугаар сар**

д/д	Өртөөний нэр	Галт тэрэгний тоо		
		төвлөвсөн	биелсэн	тасалдсан
1	Сүхбаатар	60	58	2
2	Дархан	150	149	1
3	Шарын гол	60	60	0
4	Эрдэнэт	31	31	0
5	Зүүнхараа	30	30	0
6	Улаанбаатар	192	191	1
7	Айраг	7	7	0
8	Бор-Өндөр	7	7	0
9	Сайншанд	11	11	0
10	Замын-Үүд	30	30	0
Бүгд		578	574	4



Суурь бүтцийн 2020 оны 8-р сарын хөдөлгөөний зурмагийн тасалдлын судалгаа тайлан

Зорчигчийн галт тэрэгний өнгөрүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад тасалдлын тоо **11** нэгж буюу **47.83%**-иар буурсан үзүүлэлттэй байна.



Зорчигчийн галт тэрэгний өнгөрүүлэлт 8 дугаар сар


Д/д	Өртөөний нэр	Галт тэрэгний тоо		
		төлөвлөсөн	биелсэн	тасалдсан
1	Сүхбаатар – Улаанбаатар	120	117	3
2	Дархан – Улаанбаатар	120	118	2
3	Дархан – Шарын гол	120	120	0
4	Дархан – Эрдэнэт	62	61	1
5	Зүүнхараа – Улаанбаатар	60	58	2
6	Айраг – Бор-Өндөр	14	14	0
7	Улаанбаатар – Сайншанд	22	22	0
8	Улаанбаатар – Замын-Үүд	271	267	4
Бүгд		789	777	12

Ачааны галт тэрэгний явуулалтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад тасалдлын тоо **19** нэгж буюу **61.29%**-иар буурсан үзүүлэлттэй байна.



Ачааны галт тэрэгний явуулалт 8 дугаар сар

Д/д	Өртөөний нэр	Галт тэрэгний тоо		
		төлөвлөсөн	биелсэн	тасалдсан
1	Сүхбаатар	365	363	2
2	Ерөө	195	195	0
3	Дархан-1	70	69	1
4	Дархан-2	147	145	2
5	Шарын гол	22	22	0
6	Салхит	176	176	0
7	Хөтөл	64	64	0
8	Эрдэнэт	64	64	0
9	Зүүнхараа	672	670	2
10	Толгойт	318	318	0
11	Улаанбаатар-1	365	364	0
12	Улаанбаатар-2	75	75	0
13	Амгалан	53	53	0
14	Багахангай	44	44	0
15	Маянэт	19	19	0
16	Багануур	75	75	0
17	Чойр	665	664	1
18	Шивээ-Овоо	94	94	0
19	Олон-Овоо	78	78	0
20	Айраг	118	118	0
21	Бор-Өндөр	45	45	0
22	Өргөн	28	28	0
23	Зүүнбаян	39	39	0
24	Улаан-Уул	42	42	0
25	Сайншанд	836	833	3
26	Замын-Үүд	781	781	0
Бүгд		6381	6368	12





Суурь бүтцийн 2020 оны 8-р сарын хөдөлгөөний зурмагийн тасалдлын судалгаа тайлан

Ачааны галт тэрэгний өнгөрүүлэлтийг өмнөх сартай харьцуулахад тасалдлын тоо 3 нэгж буюу 2.88% -иар буурсан үзүүлэлттэй байна.





Ачааны галт тэрэгний өнгөрүүлэлт (8 дугаар сар)

Д/Д	Өртөөний нэр	Галт тэрэгний тоо		
		төлөвлөсөн	бичлэсэн	тасалдсан
1	Сүхбаатар – Зүүнхараа	316	308	8
2	Сүхбаатар – Дархан	76	76	0
3	Ерөө – Зүүнхараа	155	152	3
4	Дархан – Шаран гол	36	36	0
5	Дархан – Салхит	110	110	0
6	Дархан – Зүүнхараа	146	143	3
7	Салхит – Эрдэнэт	121	117	4
8	Зүүнхараа – Улаанбаатар	672	653	19
9	Улаанбаатар – Багануур	133	131	2
10	Улаанбаатар – Чойр	645	623	22
11	Багахангай – Чойр	31	31	0
12	Багахангай – Улаанбаатар	28	28	0
13	Багахангай – Багануур	6	6	0
14	Чойр – Сайншанд	739	720	19
15	Дархан – Бэр-Өндөр	87	86	1
16	Сайншанд – Зүүнбаян	84	84	0
17	Сайншанд – Замын-Үүд	782	762	20
Бүгд		4167	4066	101

Нийт 129 тасалдал бүтгэгдсэнээс хамгийн их буюу 66 нэгжийг зүтгүүрийн гэмтлээс үүдсэн тасалдал эзэлж байна.

Зүтгүүртэй холбоотой 66 тасалдалын 37(56.06%) нэгжийг 2ТЭ116УМ серийн зүтгүүр, 11(16.67%) нэгжийг 2ТЭ25КМ серийн зүтгүүр, 8 (12.12%) нэгжийг 2ТЭ-116 серийн зүтгүүр, 5(7.57%) нэгжийг 2ТЭ116УД серийн зүтгүүр, 3(4.55%) нэгжийг 23АГАЛ серийн зүтгүүр, 2(3.03%) нэгжийг 2М62 ММ серийн зүтгүүрүүд нь тус тус эзэлж байна.



Нийтдээ хохирлын хэмжээ 21'576'166₮ болсон байна. Үүнээс зүтгүүрийн гэмтэл болон зүтгүүрийн гэмтлээс үүдэлтэй саатсан хохирлын хэмжээ 12'789'356 (59.28%) төгрөг, хоорондын замд саатсан галт тэргийг хүлээн зогсож зурмагаас гарсан тасалдлын хохирлын хэмжээ 2'350'944 (10.89%) төгрөг эзэлж байна.

Мөн технологийн зөрчил буюу ажилчдын буруутай үйлдлээс үүдсэн тасалдлын хохирлын хэмжээ 1'932'596 (8.95%) төгрөг, төмөр замын гарам, төмөр зам дээр хүн, машин, мал байсан болон дайрагдсанаас шалтгаалан гарсан тасалдлын хохирлын хэмжээ 2'162'015 (10.02%) төгрөг, Сирдп-Е-ийн сүлжээ тасалдлын улмаас үүссэн тасалдлын хохирлын хэмжээ 1'727'580 (8.01%) төгрөг, бусад шалтгаантай тасалдлын хохирлын хэмжээ 613'675 (2.84%) төгрөг, болж тус тус эзэлж байна.



LTE сүлжээний талаарх сонирхолтой мэдээ

LTE-R сүлжээ нь 4-р үеийн үүрэн холбооны (3GPP Long Term Evolution) LTE сүлжээнээс салбарлан гарсан стандарт юм.

БНСУ-ын 2017 оны 12 сард Вонжу - Ганниён чиглэлд дэлхийд анхны 4G LTE-R сүлжээг ашиглалтанд оруулсан. 250 км/цаг хурдтай өндөр хурдны галт тэрэгний шугамыг 2018 оны Пьёнчаны өвлийн олимпод бэлтгэн 7 өртөөг дамнансан LTE-R сүлжээтэй 120 км замыг тавьсан.



- LTE-R сүлжээний мэдээлэл дамжуулах суваг олон (Voice + Video + Data);
- LTE сүлжээг өртөө, зөрлөг, платформ тавцан, галт тэрэгний хөдөлгөөний видео дүрс /Surveillance CCTV/ ажиглалтад ашиглаж байна.

LTE-R стандартыг Европын холбоо, БНХАУ зэрэг улс орнуудад нийтлэг байдлаар ашигладаг GSM-R, TETRA сүлжээтэй харьцуулсан хүснэгтийг доор харуулав.

Параметер	GSM-R	TETRA	LTE-R
Давтамж	DL: 921-925 МГц, UL: 876-880 МГц	380-400 410-430 450-470 806-821/851-866 МГц	450, 800 МГц, 1.4 ГГц and 1.8 ГГц
Сувгийн зурвасын өргөн	200 кГц	25 кГц	1.4, 3, 5, 10, 15, 20 МГц
Сувгийн тоо	8	4	10 мс фрейм тэмдэгтээр
Өгөгдөл дамжуулах хурд	DL - 172 кбит/с UL - 172 кбит/с	25 кГц-д 115.2 кбит/с 150 кГц-д 691.2 кбит/с	>50-150 Мбит/с >10-50 Мбит/с
IP хаяг дэмждэг	Үгүй	Дэмждэг болсон	Тийм
Стандарт	UIC (Union Internationale des Chemins de Fer), EIRENE & MORANE	European Telecommunications Standards Institute	UIC and 3GPP LTE release 11
Модуляци	GMSK TDMA	DPSK TDMA	QPSK, 16-QAM and 64-QAM (OFDM, SCFDMA)
Хөгжүүлэгдсэн байдал	Бүрэн нэвтэрсэн, 2025 оноос хэрэглээнээс гаргах төлөөтэй	Бүрэн нэвтэрсэн	Бүрэн нэвтэрсэн, зарим улс орнууд төмөр замдаа нэвтрүүлээд эхэлж байгаа.
Бааз станц хоорондын зай	5-10 км	10-25 км	1-5 км
Тасралтгүй холбогдох галт тэрэгний хурдны хагаар	500 км/цаг, үүнээс 300 км/цагт зохистой	500 км/цаг үүнээс 250 км/цагт зохистой	350-750 км/цаг үүнээс 300 км/цагт зохистой
Дамжуулах агуулгын төрөл	Дуу авиа, бага урсгалтай өгөгдөл	Дуу авиа, бага урсгалтай өгөгдөл	Дуу авиа, видео, өндөр урсгалтай өгөгдөл



**Газар бизнес төвийн байр,
Тээвэрчдийн гудамж,
2-р хороолол, 1-р хороо,
Баянгол дүүрэг, 16052,
Улаанбаатар хот, Монгол улс**

